



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/049/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimeg.ts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Наранбат Утас: 261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН
ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.ТЭГШБАЯР ТАНАА

2025.04.08 № 07/1405
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 2024 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх 735,000.0 мянган ам.долларын Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Европын хөрөнгө оруулалтын банк гэсэн 3 зээлийн гэрээг эх үүсвэр тус бүрээр 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Сангийн яам Азийн Хөгжлийн Банктай байгуулсан. Төслийн үйл ажиллагаа 3 үе шаттайгаар 2024 оноос 2034 оныг дуустал 10 жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн эхний жилийн санхүүжилт болох 45,000.0 мянган ам.долларыг Азийн Хөгжлийн Банкны зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр батлагдсанаас тайлангийн хугацаанд зээлийн цэвэр ашиглалт 594.4 мянган ам.доллар буюу 2,003.654.2 мянган төгрөг байна.

Бусад асуудлын хэсэг

Төсөл Хэрэгжүүлэгч Нэгжийн тайлант оны төлөвлөгөөнд 4 хөтөлбөрийн хүрээнд 19 арга хэмжээ, ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	339,398,947.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	331,382,947.62
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	331,382,947.62
3121	Төгрөг	-	49,932,045.83
31211	Төрийн сангийн харилцах		49,932,045.83
3122	Гадаад валют	-	281,450,901.79
31221	Төрийн сангийн харилцах		281,450,901.79
33	АВЛАГА		8,016,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		4,000.00
335	Бусад авлага		8,012,000.00
3351	Байгууллагаас авах авлага		7,996,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		16,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	823,455,317.50
392	Биет хөрөнгө	-	780,565,317.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл		566,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(14,150,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		163,853,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(14,211,830.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		83,063,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(3,989,152.50)
393	Биет бус хөрөнгө	-	42,890,000.00
39301	Программ хангамж		47,464,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(4,574,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	1,162,854,265.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-
413	Өглөг		-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	1,162,854,265.12
51	Засгийн газрын хувь оролцоо		1,162,854,265.12
512	Хуримтлагдсан үр дүн		1,162,854,265.12
51220	Тайлант үеийн үр дүн		1,162,854,265.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	1,162,854,265.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	2,090,364,049.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,090,364,049.25
120	Нийтлэг татварын бус орлого		2,090,364,049.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,090,364,049.25
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих L4307		2,003,341,955.12
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		87,022,094.14
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	934,558,489.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	934,558,489.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	934,558,489.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	603,723,445.13
210101	Үндсэн цалин		603,723,445.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	73,528,623.89
210201	Тэтгэврийн даатгал		51,719,137.82
210202	Тэтгэмжийн даатгал		6,084,604.44
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,233,597.23
210204	Ажилгүйдлийн даатгал		2,479,292.89
210205	Эрүүл мэндийн даатгал		10,011,991.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	92,669,645.75
210301	Гэрэл, цахилгаан		355,621.20
210304	Байрны түрээс		92,314,024.55
2104	Хангамж, бараа материалын зардал	-	32,398,507.96
210401	Бичиг хэрэг		11,790,900.00
210402	Тээвэр, шатахуун		18,004,499.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,603,108.00
2107	Томилолт, зочны зардал	-	74,796,792.99
210702	Дотоод албан томилолт		74,796,792.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	20,268,091.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,597,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		9,574,224.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,927,207.29
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		169,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	37,173,382.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		248,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		36,924,982.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	1,155,805,559.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		7,048,705.38
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		7,048,705.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		7,048,705.38
5	НИЙТ ҮР ДҮН	-	1,162,854,265.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	2,003,341,955.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,003,341,955.12
120	Нийтлэг татварын бус орлого		2,003,341,955.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,003,341,955.12
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих L4307		2,003,341,955.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,164,462,258.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,164,462,258.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,164,462,258.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	603,723,445.13
210101	Үндсэн цалин		603,723,445.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	73,528,623.89
210201	Тэтгэврийн даатгал		51,719,137.82
210202	Тэтгэмжийн даатгал		6,084,604.44
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,233,597.23
210204	Ажилгүйдлийн даатгал		2,479,292.89
210205	Эрүүл мэндийн даатгал		10,011,991.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	95,787,992.00
210301	Гэрэл, цахилгаан		323,292.00
210304	Байрны түрээс		95,464,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	29,884,734.51
210401	Бичиг хэрэг		10,719,000.00
210402	Тээвэр,шатахуун		16,531,363.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,634,370.91
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	268,527,547.27
210601	Багаж, техник, хэрэгсэл		193,015,727.27
210602	Тавилга		75,511,820.00
2107	Томилолт, зочны зардал	-	73,629,918.00
210702	Дотоод албан томилолт		73,629,918.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	19,138,097.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,420,740.30
210803	Даатгалын үйлчилгээ		8,703,840.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,843,857.24
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		169,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	241,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		241,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	838,879,696.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	514,545,454.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		514,545,454.54
2200	Дотоод эх үүсвэрээр		514,545,454.54
222001	Тоног төхөөрөмж		514,545,454.54
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(514,545,454.54)

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	7,048,705.38
14	Бусад эх үүсвэр		7,048,705.38
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		7,048,705.38
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	7,048,705.35
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	331,382,947.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	331,382,947.62

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцоо нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
4	Тайлант үеийн үр дүн			
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
8	Тайлант үеийн үр дүн	-	1,162,854,265.12	1,162,854,265.12
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,162,854,265.12	1,162,854,265.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,053,000,000.00	1,679,007,712.88	373,992,287.12	81.8
УРСГАЛ ЗАРДАЛ	1,201,000,000.00	1,164,462,258.34	36,537,741.66	97.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,201,000,000.00	1,164,462,258.34	35,537,741.66	97.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,000,000.00	603,723,445.13	11,276,554.87	98.2
Үндсэн цалин	615,000,000.00	603,723,445.13	11,276,554.87	98.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,668,000.00	73,528,623.89	7,139,376.11	91.1
Тэтгэврийн даатгал	53,000,000.00	51,719,137.82	1,280,862.18	97.6
Тэтгэмжийн даатгал	7,521,500.00	6,084,604.44	1,436,895.56	80.9
ҮОМШӨ-ний даатгал	3,760,800.00	3,233,597.23	527,202.77	86.0
Ажилгүйдлийн даатгал	3,760,800.00	2,479,292.89	1,281,507.11	65.9
Эрүүл мэндийн даатгал	12,624,900.00	10,011,991.51	2,612,908.49	79.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,822,200.00	95,787,992.00	1,034,208.00	154.5
Гэрэл, цахилгаан	585,000.00	323,292.00	261,708.00	55.3
Байрны түрээс	96,237,200.00	95,464,700.00	772,500.00	99.2
Хангамж, бараа материалын зардал	32,960,000.00	29,884,734.51	3,075,265.49	90.7
Бичиг хэрэг	10,730,000.00	10,719,000.00	11,000.00	99.9
Тээвэр, шатахуун	16,570,000.00	16,531,363.60	38,636.40	99.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,660,000.00	2,634,370.91	3,025,629.09	46.5
Эд хогшил, урсгал засварын зардал	268,675,500.00	268,527,547.27	147,952.73	99.9
Багаж, техник, хэрэгсэл	193,075,500.00	193,015,727.27	59,772.73	99.9
Тавилга	75,600,000.00	75,511,820.00	88,180.00	99.9
Томилолт, зочны зардал	73,714,300.00	73,629,918.00	84,382.00	99.9
Дотоод албан томилолт	73,714,300.00	73,629,918.00	84,382.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,560,000.00	19,138,097.54	13,421,902.46	58.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,478,500.00	7,420,740.30	10,057,759.0	42.5
Даатгалын үйлчилгээ	11,000,000.00	8,703,840.00	2,296,160.00	79.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,906,500.00	2,843,857.24	1,062,642.76	72.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	175,000.00	169,660.00	5,340.00	96.9
Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	241,900.00	358,100.00	40.3
Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	241,900.00	358,100.00	40.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	852,000,000.00	514,545,454.54	337,454,545.46	60.6
Дотоод эх үүсвэрээр	852,000,000.00	514,545,454.54	337,454,545.46	60.6
Барилга байгууламж	3,000,000.00	-	3,000,000.00	
Тоног төхөөрөмж	849,000,000.00	514,545,454.54	334,454,545.46	60.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,053,000,000.00	2,003,341,955.12	49,658,044.88	98.1

Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,043,000,000.00	2,003,341,955.12	39,658,044.88	98.1
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,043,000,000.00	2,003,341,955.12	39,658,044.88	98.1
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	10,000,000.00	-	10,000,000.00	-
Хандив тусламж /гадаад/	10,000,000.00	-	10,000,000.00	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		7,048,705.38		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		331,382,947.62		
Ажиллагсдын тоо	41	17	24	41.5
Удирдах ажилтан	5	4	1	80.0
Гүйцэтгэх ажилтан	32	9	23	28.1
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 37,215.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оффисын түрээсийн барьцаа 7,776.0 мянган төгрөг, юнителийн дугаарын барьцаа 220.0 мянган төгрөгийг авлагын тооцоо үүсгээгүй зардлаар бүртгэсэн.	1	7,996.0			1	7,996.0	1	7,996.0				
Тээврийн хэрэгсэлд ашиглахаар шинээр худалдан авсан 5,236.3 мянган төгрөгийн өвлийн 8 дугуйг шууд зардлаар бүртгэсэн.	1	5,236.3			1	5,236.3	1	5,236.3				
Цалингийн зардалд 1,920.6 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг тайлагнасан.	1	1,920.6			1	1,920.6	1	1,920.6				
Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардлыг 14,150.0 мянган төгрөгөөр илүү тооцсон.	1	14,150.0			1	14,150.0	1	14,150.0				
НӨАТ суутган татвар төлөгч биш иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 7,912.6 мянган төгрөгийн худалдан авалтыг НӨАТ-н чөлөөлөлтөөр тайлагнасныг тус тус залруулж бүртгэсэн.	1	7,912.6			1	7,912.6	1	7,912.6				
Дүн	5	37,215.5			5	37,215.5	5	37,215.5				

3.2. Аудитаар нийт 35,429.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,256.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 33,172.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баян-өлгийн, Ховд, Увс аймагт салбар байгуулахаар нэгдсэн төслөөс томилолтоор явсан 2,256.5 мянган төгрөгийн шатахууны тооцоог замын хуудас, шатахууны орлого, зарлагын гүйлгээг нотлох баримт, зарцуулалтыг хянасан баталгаажилтгүй зардлаар бүртгэсэн байна.	1	2,256.5			1	2,256.5						
Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаанд төлөгдсөн 29,772.7 мянган төгрөгийн түрээсийн төлбөр, үйл ажиллагааны зардлыг цахим төлбөрийн и баримтаар баталгаажуулаагүй байна.	1	29,772.7					1	29,772.7				
Canon 2925 маркийн хувилагч машиныг нийлүүлэгчээс шинээр худалдан авч 2024 оны 07 дугаар сард бүртгэлд тусгаж, ашиглалтад оруулсан боловч уг хувилагч машинд 2024 оны 12 дугаар сард дахин 3,400.0 мянган төгрөгийн шинэ бул худалдан авч бичиг хэргийн зардлаар тайлагнасан.	1	3,400.0					1	3,400.0				
Дүн	3	35,429.2			1	2,256.5	2	33,172.7				